



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Дундговь аймгийн Дэлгэрхангай сумын 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: ДУА-2024/13/НА-СТА-ТТЗ

Цахим хуудас:

www.audit.mn

Дундговь аймаг

2024 он

Дарга, тэргүүлэх аудитор: Р.Мөнхтогтох

Утас: 70592439

Цахим хаяг: Munkhtogtokhr@audit.gov.mn

Аудитын менежер: Х.Наранцацрал

Утас: 70592225

Цахим хаяг: Narantsatsralkh@audit.gov.mn

Ахлах аудитор: Д.Ихбаяр

Утас: 70593113

Цахим хаяг: ikhbayard@audit.gov.mn

Аудитор: Т.Оюун-Эрдэнэ

Утас: 70593113

Цахим хаяг: oyunerdenet@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



ДУНДГОВЬ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Нутгийн удирдлагын ордон, 7-р баг, Сайнцагаан сум
Дундговь аймаг 48090 Утас: 70592439, 70592208,
70593208, Цахим хаяг: dundgovi@audit.gov.mn

2024-03-25 № 115

танай _____ -ны № _____ -т

ДУНДГОВЬ АЙМГИЙН
ДЭЛГЭРХАНГАЙ СУМЫН ЗАСАГ
ДАРГА Ц.ОДБАЯР ТАНАА

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.3-т заасны дагуу Дундговь аймгийн Дэлгэрхангай сумын Засаг даргын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дундговь аймгийн Дэлгэрхангай сумын Засаг даргын 203 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Санхүүгийн тайлангийн тухай хэрэглэгчдийн анхаарал хандуулах, ач холбогдолтой зүйлийн талаар тодруулахад тайлант онд Дундговь аймгийн Дэлгэрхангай сумын Засаг даргын санхүүгийн нэгтгэсэн тайлангийн нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 1.2 дахин буюу 417.9 сая төгрөгөөр өссөн байна. Энэ нь тайлант онд сумын Засаг даргын Тамгын газар 506.7 сая төгрөгийн үндсэн хөрөнгийг үнэ төлбөргүй хүлээн авсантай холбоотой байна. Уг үйл явцыг санхүүгийн тайланд толилуулсан бөгөөд санхүүгийн тайланд толилуулаагүй асуудал гараагүй болно.

Тус байгууллагын чиг үүрэг нь өөрчлөгдөж татан буугдах, нэгдэх асуудал гараагүй бөгөөд үйл ажиллагаагаа тасралтгүй явуулахтай холбоотой тодорхой бус байдал үүсээгүй.

Аудитын гол асуудал

Дундговь аймгийн Дэлгэрхангай сумын Засаг даргын санхүүгийн нэгтгэсэн тайланд нэгтгэгдсэн Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөс 2023 онд санхүүжүүлэх хөрөнгө оруулалт төсөл арга хэмжээг төсөв, техник, эдийн засгийн үндэслэлгүй, байгаль орчны төлөв байдлын үнэлгээ хийгдээгүй төсөл, арга хэмжээнд зарцуулахаар төлөвлөж баталсан, төсөл арга хэмжээг Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийг 2023 онд

хэрэгжүүлэх төлөвлөгөөнд тусгаагүй зэрэг зөрчил нь тайлант үеийн удирдлагын үлэмж хэмжээний шийдэл орсон асуудал байлаа.

Бусад асуудлын хэсэг

Аудитыг гүйцэтгэхэд аудитын хамрах хүрээний хязгаарлалт хийх шаардлагагүй болон хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй нөхцөл үүсээгүй тул бидний олж авсан нотолгоо нь аудитын дүгнэлтийн суурь болоход хүрэлцээтэй зохистой гэж үзлээ.

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Байгууллагын жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 5 хөтөлбөр, 28 зорилт, 144 арга хэмжээг бүрэн хэрэгжүүлж, гүйцэтгэлийн төлөвлөгөөний үнэлгээгээр 92.2 хувийн гүйцэтгэлтэй тайлагнасан байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Р.МӨНХТОГТОХ



2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан

/мянган төгрөгөөр/

Код:	Тайлангийн үзүүлэлт	2022оны 12-р сарын 31	2023 оны 12-р сарын 31
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	733,191.9	771,715.4
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	505,116.2	398,247.7
33	АВЛАГА	37,212.1	168,271.8
35	БАРАА МАТЕРИАЛ	190,863.5	205,195.9
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	1,105,995.8	1,485,403.4
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	1,105,995.8	1,485,403.4
39200	Биет хөрөнгө	1,017,784.8	1,393,224.9
39300	Биет бус хөрөнгө	88,211.0	92,178.5
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	1,839,187.6	2,257,118.8
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	163.0	1,542.0
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	163.0	1,542.0
41300	Өглөг	163.0	1,542.0
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	1,839,024.6	2,255,576.8
51	Засгийн газрын хувь оролцоо	1,839,024.6	2,255,576.8
51100	Засгийн газрын оруулсан капитал	476,916.6	476,916.6
51200	Хуримтлагдсан үр дүн	1,194,769.5	1,611,321.6
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	167,338.5	167,338.5
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	1,839,187.6	2,257,118.8

2.2 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан

/мянган төгрөгөөр/

Код:	Тайлангийн үзүүлэлт	2022оны 12-р сарын 31	2023 оны 12-р сарын 31
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	1,600,063.0	1,798,823.5
11	ТАТВАРЫН ОРЛОГО	271,509.2	332,699.1
110	Орлогын албан татвар	162,593.8	211,221.4
1100	Хувь хүний орлогын албан татвар	162,593.8	211,221.4
113	Хөрөнгийн албан татвар	53,186.3	45,684.8
118	Бусад татвар, төлбөр, хураамж	55,729.0	75,792.8
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	405,739.0	402,162.1
120	Нийтлэг татварын бус орлого	405,739.0	402,162.1
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	922,814.9	1,063,962.3
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	1,184,469.6	1,238,527.1
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,184,469.6	1,238,527.1
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	786,835.8	859,479.5
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	271,473.5	390,261.9
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	33,696.6	47,689.2
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	20,551.0	27,415.6
2104	Хангамж, бараа материалын зардал	170,647.4	41,480.1
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	27,376.4	12,848.6
2107	Томилолт, зочны зардал	11,701.0	19,594.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	27,440.8	33,204.1
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	223,949.3	286,986.1
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	397,633.7	379,047.6
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	415,593.4	560,296.4
V	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	5,588,434.9	143,744.9

Дундговь аймгийн Дэлгэрхангай сумын 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	-5,172,841.5	416,551.5
----	--	---------------------	------------------

2.3 Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/мянган төгрөгөөр/

Код:	Тайлангийн үзүүлэлт	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн	Нийт цэвэр хөрөнгө/өмч
1	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	7,117,850.6	7,117,850.6
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-105,984.5	-105,984.5
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	7,011,866.1	7,011,866.1
9	Тайлант үеийн үр дүн	-5,172,841.5	-5,172,841.5
10	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,839,024.6	1,839,024.6
11	2023 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	1,839,024.6	1,839,024.6
12	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.7	0.7
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,839,025.3	1,839,025.3
19	Тайлант үеийн үр дүн	416,551.5	416,551.5
20	2023 оны 6-р сарын 30-наарх үлдэгдэл	2,255,576.8	2,255,576.8

2.4 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан

/мянган төгрөгөөр/

Код:	Тайлангийн үзүүлэлт	2022оны 12-р сарын 31	2023 оны 12-р сарын 31
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	1,285,630.3	1,591,496.4
11	ТАТВАРЫН ОРЛОГО	271,509.2	332,727.9
110	Орлогын албан татвар	162,593.8	211,250.2
1100	Хувь хүний орлогын албан татвар	162,593.8	211,250.2
113	Хөрөнгийн албан татвар	53,186.3	45,684.8
118	Бусад татвар, төлбөр, хураамж	55,729.0	75,792.8
1180	Бусад нийтлэг төлбөр, хураамж	4,977.6	5,541.0
1181	Газрын төлбөр	50,751.5	69,963.9
1182	Байгалийн нөөц ашигласны төлбөр	0.0	288.0
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	96,718.1	197,356.6
120	Нийтлэг татварын бус орлого	96,718.1	197,356.6
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	917,403.0	1,061,411.8
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	902,929.7	1,080,735.2
21	УРСГАЛ ЗАРДАЛ	902,929.7	1,080,735.2
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	846,105.4	1,054,986.1
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	337,805.7	390,083.9
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	40,408.6	47,688.5
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	278,508.7	27,415.6
2104	Хангамж, бараа материалын зардал	37,108.5	36,329.9
2105	Нормативт зардал	0.0	650.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	36,496.0	16,781.3
2107	Томилолт, зочны зардал	11,701.0	19,594.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	27,440.8	385,194.5
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	76,636.2	131,248.5
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	56,824.3	25,749.2
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	382,700.6	510,761.2
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	327,237.5	459,229.7
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	327,237.5	459,229.7
2200	Дотоод эх үүсвэрээр	327,237.5	459,229.7

Дундговь аймгийн Дэлгэрхангай сумын 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	-327,237.5	-459,229.7
VII	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН	0.0	-158,400.0
23	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	0.0	158,400.0
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	55,463.1	-106,868.6
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	449,653.1	505,116.2
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	505,116.2	398,247.7

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/мянган төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Төсвийн гүйцэтгэлийн тайлан
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	2,058,079.4	1,662,144.6
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,124,002.1	1,062,889.8
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,104,124.2	1,043,200.8
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	399,604.5	390,083.9
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	48,997.0	47,688.5
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	351,362.9	348,599.5
2104	Хангамж, бараа материалын зардал	35,058.2	34,194.9
2105	Нормативт зардал	650.0	650.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	61,198.1	59,050.8
2107	Томилолт, зочны зардал	19,234.0	18,694.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	17,986.7	17,736.1
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	170,032.8	126,503.2
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	19,877.9	19,689.0
2132	Бусад урсгал шилжүүлэг	19,877.9	19,689.0
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	715,878.3	440,854.7
23	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	218,199.0	158,400.0
III	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	2,058,079.4	1,529,576.0
31	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	381,054.2	381,054.2
32	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	1,086,400.8	1,001,570.9
35	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	590,624.4	146,950.9
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	443,664.1
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	311,095.5

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

/мянган төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	ТЗ цэвэр дүн
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	33,786.8
21	УРСГАЛ ЗАРДАЛ	33,786.8
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	29,358.4
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	3,560.9
2104	Хангамж, бараа материалын зардал	2,134.9
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	3,300.0
2107	Томилолт, зочны зардал	900.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	15,519.0
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	3,943.5
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	4,428.3
I	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	33,786.3

Дундговь аймгийн Дэлгэрхангай сумын 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	33,786.3
III	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)	(0.5)
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0.5
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-

3. Аудитын илрүүлэлт

3.1 Сумын санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитаар илэрсэн алдаа, зөрчилтэй асуудал

Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитаар алдаа, зөрчил илрээгүй.

3.2 Сумын нэгтгэсэн тайланд нэгтгэгдсэн төсвийн шууд захирагчдын санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн алдаа, зөрчилтэй асуудал

Сумын 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд харьяа 2 төсвийн байгууллага, 4 тусгай сангийн нийт 6 санхүүгийн тайлан нэгтгэгдсэнээс 1 байгууллагад дүгнэлт гаргаж, 5 байгууллага түүвэрт хамрагдсан байна.

Аудитад хамрагдсан Засаг даргын Тамгын газрын санхүүгийн тайланд “Өөрчлөлтгүй” санал дүгнэлт өгсөн байна.

Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн талаарх мэдээллийн нэгтгэл:

№	Төсвийн захирагчийн ангилал	Байгууллага, нэгжийн тоо				Санал дүгнэлтийн хэлбэр			
		Аудитад хамрагдах	Үүнээс: Аудит хийсэн хэлбэр			Өөрчлөлтгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс татгалзсан
			Санал дүгнэлт гаргасан	Түүвэрт хамруулсан	Аудит хийгээгүй				
A	1	2	3	4	5	7	8	9	10
1	Засаг даргын Тамгын газар	1	1			1			
2	Иргэдийн Төлөөлөгчдийн хурал	1		1					
3	Мал хамгаалах сан	1		1					
4	Хоршоо хөгжүүлэх сан	1		1					
5	Орон нутгийн хөгжлийн	1		1					
6	Байгаль хамгаалах сан	1		1					
	НИЙТ	6	1	5		1			

Харьяа байгууллагуудын санхүүгийн тайланд хийсэн аудитаар нийт 761,169.8 мянган төгрөгийн алдаа, зөрчил илрүүлснээс аудитын явцад 4,435.5 мянган төгрөгийн алдааг залруулж, 1,696.0 мянган төгрөгийн 2 зөрчилд төлбөрийн акт тогтоож, 755,038.2 мянган төгрөгийн 13 зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүллээ. Үүнээс аудитаар илрүүлсэн алдаа, зөрчлийн 94.4 хувийг залруулагдаагүй, 0.6 хувийг залруулсан алдаа тус тус эзэлж байна.

Төсөвт байгууллагуудын 2023 санхүүгийн үйл ажиллагаанд хийсэн завсрын аудитаар илэрсэн зөрчлийг арилгуулахаар хүргүүлсэн 755,038.0 мянган төгрөгийн 11 албан шаардлага, 1 заалт зөвлөмжийг хэрэгжүүлэн нотлох баримтыг ирүүлсэн байна. Жилийн эцсийн санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн залруулагдах боломжгүй, аудитын дүгнэлтэд нөлөөлөх 5,856.0 мянган төгрөгийн зөрчил нь тогтоосон материаллаг түвшингээс 3.2 дахин бага байна.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

4. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл:

№	Байгууллагын нэр	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
								Залруулсан		Залруулаагүй			
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Засаг даргын Тамгын газар	1	4,435.5			1	4,435.5	1	4,435.5				
	Дүн	1	4,435.5			1	4,435.5	1	4,435.5				

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл :

д/д	Байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс:									
				Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Засаг даргын Тамгын газар	4	500.0	1	500.0	3	-						
2	Тусгай зориулалтын сан	2	5,356.0	1	1,196.0	1	4,160.0						
	Нийт зөрчлийн дүн	6	5,856.0	2	1,696.0	4	4,160.0	-	-	-	-	-	-

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал:

Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1. Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Засаг даргын Тамгын газар	1	-			1	-		
Иргэдийн Төлөөлөгчдийн хурал	1	-			1	-		
Дүн	2	-			2	-		
2. Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
Орон нутгийн хөгжлийн сан	5	750,878.3			5	750,878.3		
Засаг даргын Тамгын газар	1	-			1	-		
Хоршоо хөгжүүлэх сан	1	-			1	-		
Дүн	7	750,878.3			7	750,878.3		
Нийт дүн	9	750,878.3			9	750,878.3		